



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/70

Сүхбаатар сум

Коронавириусийн /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", 29.1.6 "а", "л", "ж", "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, 11.1.8, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай /Шинэ коронавириусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/ 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Шинэ коронавириусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. БНХАУ-д гарсан шинэ коронавириусийн халдвар /COVID-19/-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан эзэнгүй, золбин муур, нохойг устгах, устгасны дараах ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хууль тогтсомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Усны шувуудын нүүдэл эхлэхтэй холбогдуулан ирж буудаг гол, нуур, цөөрмийн орчим болон тахиа, шувууны фермерийн ариутгал, халдваргүйтгэлийг холбогдох аж ахуй нэгж байгууллага, сумдтай хамтран зохион байгуулахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар, Зооноз өвчин судлалын төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Ариутгал, халдваргүйтгэл хийж буй байгууллагуудын бодис зохих шаардлага, найрлагад хүрч буй эсэх, болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй эсэхэд хяналт

тавьж, холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын дарга, хурандаа Г.Баатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ